

БАТЛАВ:

**ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН
САЙД**

Б.БАТЗОРИГ

БАТЛАВ:

**БАРИЛГА, ХОТ
БАЙГУУЛАЛТЫН
САЙД**

Х.БАДЕЛХАН

БАТЛАВ:

**ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД
ХЭРГИЙН САЙД**

Ц.НЯМДОРЖ

БЭЛЧЭЭРИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг.Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага.

Бэлчээрийн тухай хуулийн төслийг боловсруулах дараахь хууль зүйн болон практик үндэслэл, шаардлага байна.

1.1.Хууль зүйн үндэслэл

Монгол Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-ын 3.5.2.2-т “Бэлчээр ашигласны төлбөр тогтоох, эзэмшүүлэх, хамгаалах болон нөхөн сэргээх хариуцлага хүлээлгэх чиглэлээр эрх зүйн орчныг бүрдүүлж, бэлчээрийн одоогийн төлөв байдал, цаашдын хандлагад суурилсан бэлчээрийн даацыг бүс нутаг бүрээр шинэчлэн тогтоож малын тоо толгой, төрөл, сүргийн бүтцийн зохистой харьцааг хангана” гэж,

Монгол Улсын Их Хурлын 2016 оны 19 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030”-ын зорилт 1-д “... бэлчээрийн даацад нийцсэн мал сүргийн тоо, төрлийн зохистой харьцааг бүрдүүлэх, бэлчээрийн газрын доройтлыг бууруулж, нөхөн сэргээх...” гэж,

Монгол Улсын Их Хурлын 2015 оны 104 дүгээр тогтоолоор баталсан “Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого”-ын 2.1.10, 2.1.11-д “бэлчээр болон байгалийн бусад нөөцийн зохистой ашиглалт, бэлчээрийн газар зохион байгуулалт, төлөвлөлт, удирдлагын тогтолцоог сайжруулах, отрын бүс нутаг, нөөц бэлчээрийг нэмэгдүүлэх”, “...бэлчээрийн даац, төлөв байдлын үнэлгээнд тулгуурлан малын тоо, төрөл, сүргийн бүтцийг тохируулах эдийн засгийн хөшүүрэг бий болгох, бэлчээрийг оновчтой, зөв ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх...” гэж,

Монгол Улсын Их Хурлын 2017 оны 11 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-ийн 183 дахь хэсэгт Отрын бэлчээрийг хамгаалах тухай хуулийн төслийг боловсруулж батлуулахаар;

Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.36-д “...бэлчээрийн ашиглалт, хамгаалалтыг сайжруулах, төлөв байдлыг тогтоох, хянах, сэргээн сайжруулах, доройтол, талхагдал, цөлжилтийг бууруулах, ...”, 2.37-д “мал аж ахуйн салбарын тогтвортой хөгжлийг хангахад чиглэгдсэн Бэлчээр

хамгаалах тухай хуулийг боловсруулан батлуулж, эрх зүйн таатай орчинг бүрдүүлнэ” гэж тус тус заасан байна.

1.2.Практик шаардлага

Газрын нэгдмэл сангийн 2017 оны тайлангаар Монгол Улсын нийт газар нутгийн 71,7 хувь буюу 112,1 сая га талбайг бэлчээр, хадлангийн зориулалттай газар эзэлж байна. Энэхүү газар нутаг дээр үйлдвэрлэл нь явагддаг мал аж ахуйн салбар Монгол Улсын эдийн засаг, нийгмийн тулгуур салбарын нэг бөгөөд тус салбарт 2017 оны статистик мэдээгээр нийт ажиллах хүчний 28,0¹ хувь ажиллаж дотоодын нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн 10,6² хувийг тус салбар бүрдүүлж байна.

Улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн тэргүүлэх салбарын нэг болох тус салбарын тогтвортой хөгжлийн үндэс суурь нь бэлчээр, хадлангийн газар тул эдгээр хөдөө аж ахуйн эдэлбэр газрыг зөв зохистой ашиглах, сайжруулах, хамгаалах, бэлчээр ашиглалтын бодлогыг тодорхойлох асуудал салбарын тулгамдсан асуудлуудын нэг билээ.

Манай орны судлаачид, бэлчээрийн менежментийн чиглэлээр төсөл хэрэгжүүлэгчид, мэргэжлийн байгууллага, холбоодын сүүлийн 10 гаруй жилийн туршид хийсэн судалгаа, Монгол Улсын бэлчээрийн төлөв байдлын 2016 оны үндэсний тайлангийн дүнгээс бэлчээрийн эдэлбэр газрын 57,0 хувь тодорхой хэмжээгээр доройтолд орж, 10,3 хувь байгалийн аясаар сэргэх боломжгүйгээр цөлжиж, зарим нутагт бэлчээрийн даац хэвийн хэмжээнээс 2,5-10 дахин хэтрээд байна. Малын тоо толгой жилээс жилд өсч, 2018 оны жилийн эцэст 66,5³ сая мал тооллогдсон нь хонин толгойд шилжүүлсэн үзүүлэлтээр бэлчээрийн нийт багтаамжид оногдох зохист хэмжээнээс даруй 25 гаруй сая толгойгоор хэтрээд байгаа юм. Малын тоо өсөх нь малчдын амьжиргааг дээшлүүлэхэд хувь нэмэртэй ч байгалийн даацын чадамжийн хэтрэлтийг авчирч, хүний хүчин зүйлсийн сөрөг нөлөөллөөр бэлчээрийн талхагдал, хомсдол, хөрсний доройтол, цөлжилт өдрөөс өдөрт тэлж, ургамлын бүтэц, бүрэлдэхүүнд өөрчлөлт орж, байгалийн унаган төлөв, экологийн тэнцвэрт байдал алдагдах эрсдэлд хүргээд байна.

Мөн уул уурхайн замбараагүй хайгуул, олборлолтоос үүдэлтэйгээр малын бэлчээр, хадлангийн эдэлбэр газар өөр ангилалд шилжиж, малчдын өвөлжөө, хаваржааны газар, малын бэлчээр, хадлангийн талбайд цөмөрч мал бүхий иргэд, малчдын эрх ашигт хохирол учруулахын зэрэгцээ уул уурхайн бүтээгдэхүүн тээвэрлэсэн тээврийн хэрэгслийн тасралтгүй урсгалын замын тоосжилтоос үүдэлтэйгээр хүн, малын эрүүл мэндэд шууд нөлөөлөх боллоо. Түүнчлэн хүн амын өсөн нэмэгдэж буй хүнсний эрэлт, хэрэгцээ, хүнсний зарим нэр төрлийн бүтээгдэхүүний импортыг бууруулах шаардлагаас үүдэлтэйгээр эрчимжсэн мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдэд зун, намар малаа бэлчээх, малын бэлчээр, өвс хадланг бэлтгэхтэй холбогдсон зохицуулалтыг бий болгох шаардлагатай байна.

Монгол Улсын Иргэний хууль⁴, Газрын тухай⁵ болон бусад хууль, тогтоомжид бэлчээр ашиглалт, хамгаалалттай холбоотой зарим харилцааг зохицуулсан хэдий

¹ Үндэсний статистикийн хорооны 2017 оны эмхэтгэл.

² Үндэсний статистикийн хорооны 2017 оны эмхэтгэл.

³ Үндэсний статистикийн хорооны 2017 оны эмхэтгэл.

⁴ Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2002 оны 7 дугаар.

⁵ Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2002 оны 27 дугаар.

ч бэлчээрийн эдэлбэр газрыг нарийвчилсан төлөвлөлтөнд үндэслэн зохион байгуулах, гэрээгээр ашиглуулах, ашиглалтын төлөв байдлыг үнэлэх, хариуцлага хүлээлгэх, бэлчээрийг зохистой ашиглах, байгалийн жамаараа нөхөн сэргэх нөхцөлийг бий болгох, хамгаалах асуудлыг бүрэн зохицуулж чадахгүй байна.

Газрын тухай хуульд бэлчээрийг “нийтээр, дундаа ашиглах”-аар хуульчилсан. Энэ зохицуулалт нь удаан хугацаандаа бэлчээр доройтуулсан, талхалсан, даац хэтрүүлсэн үйлдэлд хариуцлага хүлээх эзэнгүй болгож, сөрөг нөлөөлөл учруулж байна. Хяналтгүй, үнэгүй ашиглах боломжтой бэлчээрт малыг өсгөж, ашиг хүртэх сонирхол давамгайлж эхэлсэн тул малын тооны хэт өсөлт болж, бэлчээрийн чадавхи, даац хүрэлцэхгүйд хүргээд байна. Нийтээр ашиглах зохицуулалттай тул бэлчээрийг зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх ажиллагаанд хөрөнгө оруулалт хийх сонирхол байхгүй байна. Мөн бэлчээрийн гарц сайн, устай, зах зээлд ойр газарт малчид, мал бүхий иргэд олноор нүүдэллэн очиж, бэлчээрт хэт ачаалал, талхагдал үүсгэн, улмаар бэлчээр доройтох үндсэн шалтгааныг бий болгож байгаа ч хариуцлага хүлээлгэх эрх зүйн орчин дутмаг байна.

Бэлчээрийг улирлын хуваарьгүй, өнжөөж амраахгүйгээр даацаас хэтрүүлэн ашиглаж байгаа өнөөгийн байдал нь малчдыг нүүх, суух бэлчээргүй болгож, жилийн 4 улирлын туршид нэг газраа суурьшин малаа идээшлүүлэх үзэгдэл нийтлэг болж байгаа нь цаашид малын гаралтай органик бүтээгдэхүүн экспортлох боломжоо алдах, улмаар нүүдлийн мал аж ахуй устах эрсдлийг дагуулж байгаа юм. Ялангуяа бэлчээрийн мал хэрэгцээт тэжээлийнхээ 90-ээс дээш хувийг байгалийн бэлчээрээс авдаг тул бэлчээрийн ургамлын бүрэлдэхүүн, зүйл, газрын шим доройтсоноос мал тэжээлийн архаг дутагдалд орж бие нь давжаарч, ашиг шим нь буурч, өвчлөл, хорогдолд өртөмтгий болсны зэрэгцээ тэдгээрийн мах, сүүний чанар буурч, эдийн засгийн алдагдал хүлээхэд хүргэжээ. Тухайлбал, судлаачдын хийсэн тооцоогоор мах, сүүн ашиг шим, ноос, ноолуурын гарцын алдагдалаас 1 малчин өрх жилд 2.6 сая, нийт малчин өрх 368,0 орчим тэрбум төгрөг алдаж байна.

Ийнхүү харилцан уялдаатай асуудлыг цогц байдлаар харж, шийдвэрлэхгүйгээр сүүлийн 16 жилийн туршид бэлчээрийг ашиглах, хамгаалахтай холбогдсон харилцааны эрх зүйг сайжруулах талаар ярилцаар өнөөгийн нөхцөл, төлөв байдалд хүрээд байна. Энэ байдал нь цаашид мал аж ахуйн үйлдвэрлэлийг тогтвортой эрхлэх, нүүдлийн соёл иргэншлийн уламжлалт өв соёл, байгаль, экологийн тэнцвэрт байдлыг хадгалж, хойч үедээ үлдээх боломжийг улам бүр багасах болно.

Дээр дурьдсан хууль зүйн болон практик шаардлага нь бэлчээр, хадлангийн талбайг ашиглах, сайжруулах, хамгаалахтай холбоотой цогц харилцааг Газрын тухай, Газрын төлбөрийн тухай хууль болон бусад холбогдох хуулиудтай уялдуулан бие даасан хуулиар нарийвчлан зохицуулах хэрэгцээ байгааг харуулж байна.

Хоёр.Хуулийн төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Хуулийн төсөл нь Газрын тухай хуулийн үзэл баримтлалын хүрээнд бэлчээрийг ашиглах, доройтлоос сэргийлэх, сайжруулах, хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулахаар 6 бүлэгтэй бичигдэх бөгөөд төслөөр хуулийн зорилт, хууль тогтоомжийн бүрдэл, хуульд хэрэглэгдэх нэр томъёог тодорхойлж, бэлчээрийн зориулалт, ангилал, төрөл, заагийг тогтоон, бэлчээрийг ашиглуулах, бэлчээрийг үнэлэх, үнэлгээнд суурилан сайжруулах, хамгаалах, эдгээр үйл

ажиллагааг төлөвлөх, удирдан зохион байгуулах, оролцогч талуудын эрх, үүргийг тогтоох зэрэг харилцааг зохицуулахаар тусгана.

Хуулийн төсөлд бэлчээрийг ашиглуулахдаа нийтээр болон гэрээгээр ашиглуулах бэлчээрийн зохицуулалтын заагийг тогтоож, нийтээр ашиглуулах бэлчээрт байгалийн тогтцоор бий болсон гол, горхи, нуур, цөөрөм, уст цэг, хужир мараа бүхий бэлчээр болон дамжин өнгөрөх бэлчээрийг хамруулах, гэрээгээр ашиглуулах бэлчээрийг мал аж ахуй эрхлэх зориулалтын онцлог, ангилалаар зааглаж, бэлчээр ашиглах эрх бүхий этгээдийг тодорхойлно.

Гэрээгээр ашиглуулах бэлчээрийг зориулалт, ангиллын дагуу бэлчээр ашиглагчийн хүсэлт, холбогдох эрх бүхий этгээдийн дүгнэлт, шийдвэрийг үндэслэн бэлчээр ашиглалтын гэрээ байгуулан ашиглуулах, бэлчээр ашиглалтын гэрээний биелэлтэд үндэслэн гэрээг сунгах, цуцлах, дуусгавар болгох харилцааг зохицуулахаар тусгана.

Хуулийн төсөлд гэрээт бэлчээрийг зохистой ашиглах, доройтлоос сэргийлэх, сайжруулах, хамгаалах асуудлыг бэлчээр ашиглагч бүрэн хариуцахаар, харин нийтээр ашиглуулах ангилалд хамаарах бэлчээрийн ашиглалт, сайжруулалт, хамгаалалтыг төр өөрөө хариуцахаар тусгана.

Хуулийн төсөлд аймаг, нийслэл, сум, дүүрэг тус бүр бэлчээр, хадлангийн газар зохион байгуулалт, ашиглалт, хамгаалалтын төлөвлөгөөтэй байх, энэхүү төлөвлөгөө нь тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний бүрэлдэхүүн хэсэг болох, төлөвлөгөөг Газрын тухай хуульд заасны дагуу баг, хорооны Иргэдийн Нийтийн Хурлаар хэлэлцүүлж, тухайн шатны Засаг дарга өргөн мэдүүлснээр аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал баталж байхаар заана.

Гэрээгээр ашиглуулах бэлчээрийн байршил, хилийн цэс, хэмжээг бэлчээр, хадлангийн газар зохион байгуулалт, ашиглалт, хамгаалалтын төлөвлөгөөг үндэслэн бэлчээр ашиглагчдын санал, баг, хорооны Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрийг харгалзан сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал батлах, гэрээг тухайн шатны Засаг дарга бэлчээр ашиглагчтай байгуулж, гэрээ байгуулсан бэлчээрийн мэдээллийг газрын нэгдмэл сангийн тайланд тусгуулахаар газрын асуудал хариуцсан албан тушаалтанд тухай бүр хүргүүлж байхаар зохицуулна.

Газрын нэгдмэл сангийн мэдээлэлд үндэслэн улсын чанартай дамжин өнгөрөх бэлчээрийн хэмжээ, хилийн цэсийг мал эмнэлгийн хорио цээрийн хяналтын цэгийг дайруулан Засгийн газар, орон нутгийн чанартай дамжин өнгөрөх бэлчээрийг хэмжээ, хилийн цэсийг аймгийн Засаг дарга тогтоохоор тусгах ба тэдгээр бэлчээрийг ашиглах нийтлэг журмыг эрх бүхий этгээд батлахаар заана. Эрчимжсэн мал аж ахуй эрхлэх зориулалтаар барилга, байгууламж барих, дэд бүтэц бий болгох тохиолдолд шаардлагатай газрыг Газрын тухай хуульд заасны дагуу шийдвэрлүүлэхээр тусгана.

Хуулийн төсөлд Монгол Улсын нийт бэлчээрийн 10-аас доошгүй хувийг отрын нөөц бэлчээрт авч байх, аймаг дундын бэлчээрийг хариуцан зохион байгуулах чиг үүргийг шинэ бүтэц бий болгохгүйгээр одоогийн бүтцийн чиг үүрэгт хариуцуулахаар хуулийн төсөлд тусгана. Байгалийн гамшиг, гэнэтийн бусад аюулын улмаас өөр аймаг, сумын нутаг дэвсгэрт нүүдэллэх шаардлага гарвал тухайн шатны Засаг дарга нар уг асуудлыг бэлчээрийн даацад нийцүүлэн хэлэлцэн шийдвэрлэх, харин

сум дотроо нүүдэллэх бол тухайн сумын Засаг дарга шийдвэрлэх, гамшиг, аюулын тохиолдолд малчдын бүлгийн гэрээгээр ашиглаж байгаа бэлчээрт бусдын мал оруулах асуудлыг гэрээний онцгой нөхцөлд тусгах, бэлчээр ашиглалтын гэрээний нийтлэг загварыг газрын болон хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батлахаар заана.

Хуулийн төсөлд бэлчээрт авто зам гаргах, бэлчээрийн хөрсийг эвдэх, бохирдуулах, бэлчээрийн эрүүл ахуйг алдагдуулах, цөл, цөлөрхөг хээрийн бүсийн болон хөрсний эвдрэл, цөлжилт үүсэх нөхцөл бүрдсэн бэлчээрт ургамал түүх, хадахыг хориглох заалт тусгана.

Түүнчлэн хуулийн төсөлд бэлчээрийг доройтлоос сэргийлэх, сайжруулах, хамгаалах зорилгоор бэлчээрийн төлөв байдлыг үнэлэх, бэлчээрийн төлөв байдал, чанарын үнэлгээ, дүрсжүүлсэн хяналт шинжилгээний дүгнэлтийг үндэслэн бэлчээр ашиглуулах гэрээг байгуулах, сунгах, бэлчээр сайжруулах, хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэх, бэлчээрийн мэдээллийн санг бүрдүүлэх, доройтсон бэлчээрийн нөхөн сэргэх чадавхийн ангилал тооцох аргачлалыг болон бэлчээрийн даац, хангамжийг тооцох аргачлал, холбогдох бусад журмыг эрх бүхий этгээд батлахаар заана.

Хуулийн төсөлд бэлчээр ашиглагч нь бэлчээрийн даацад малын тоог нийцүүлэх, бэлчээрийн даацаас хэтэрсэн малыг гэрээнд заасны дагуу үе шаттай бууруулах, бэлчээр ашигласны төлөө төлбөр төлдөг тогтолцоонд шилжих, уг төлбөрийг Газрын төлбөрийн тухай хуулиар зохицуулж, төвлөрсөн эх үүсвэрээс бэлчээрийн менежмент болон мал аж ахуйн бусад холбогдох арга хэмжээнд зарцуулдаг байх, бэлчээрт учирсан хохирлыг тооцон нөхөн төлүүлэх зэрэг харилцааг зохицуулахаар тусгана.

Хуулийн төсөлд бэлчээр ашиглах, сайжруулах хамгаалах үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалт, оролцогч талуудын эрх үүрэг, санхүүжилт, зарцуулалтын хэлбэр, бэлчээр ашиглах, хамгаалах үйл ажиллагаатай холбоотой маргаан шийдвэрлэх зохицуулалтыг тусгана.

Хууль зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг Зөрчлийн тухай хуулиар зохицуулахаар заана.

Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар

Хуулийн төсөл батлагдсанаар дараахь үр дагавар гарна гэж үзэж байна. Үүнд:

Монгол орны бэлчээрийн мал аж ахуй эрхлэх өвөрмөц онцлогт тохируулан, бэлчээрийг ашиглаж ирсэн уламжлал, зан заншилд тулгуурлан бэлчээрийн сэргэх чадавхид суурилсан ашиглалт, хамгаалалтыг төлөвшүүлэхэд чиглэгдсэн, оролцогч талуудын эрх, үүрэг, хариуцлагыг нарийвчлан зохицуулсан эрх зүйн орчин бүрдэнэ;

Бэлчээрийг хамгаалж, сайжруулах, бэлчээрийн доройтлыг цаг алдалгүй сааруулах боломж бүрдэх ба ингэснээр бэлчээр ашиглалтыг зөвхөн бэлчээрийн тэжээлийн нөөц, хүрэлцээнд чиглүүлж, бэлчээрийн тэжээлийн чанарын талыг харуулдаг төлөв байдлын менежментийг орхигдуулж ирснийг засч бэлчээрийн төлөв байдал, чанар сайжирна;

Бэлчээрийг нийтээр ашиглаж, хариуцлага хүлээдэггүй байдлыг зогсоож, бэлчээрт өөриймсөг хандаж, даацад нь тааруулан хуваарь сэлгээтэйгээр зохистой ашиглах, хөрөнгө хүч зарж хамгаалах сэтгэлгээ төлөвшин, малын тоог өсгөх биш

харин эдийн засгийн эргэлтэд оруулан борлуулах, ашиг шим, чанарыг эрхэмлэх сэтгэлгээ бий болно;

Малчин өрх бүр улирлын болон отрын бэлчээртэй байх, бэлчээрээ хамгаалах, ашиглах эрх хөндөгдсөн тохиолдолд хохирлоо нөхөн төлүүлдэг нийгмийн тэгш, шударга ёс хангагдах ба бэлчээрийн ангиллаас бусад ангилалд шилжихэд малчид, нутгийн захиргаа, мал аж ахуйн салбарын эрх ашгийг зохистой харгалздаг нөхцөл бүрдэнэ;

Бэлчээрийн унаган төрхийг сэргээн хадгалснаар байгалийн бэлчээрийн малын гаралтай хүнс, түүхий эд, бүтээгдэхүүнээр олон улсын зах зээлд өрсөлдөж, эдийн засгийг солонгоруулах гарцыг нээх, эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэн өсөн нэмэгдэж байгаа дотоодын болон экспортын хэрэгцээг хангах боломж бүрдэнэ.

Дөрөв.Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай хэрхэн уялдах түүнийг хэрэгжүүлэх зорилгоор цаашид боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах хууль тогтоомжийн талаар

Хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулна. Хуулийн төсөлтэй холбогдуулан Газрын тухай, Газрын төлбөрийн тухай, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай, Татварын ерөнхий хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай, Төсвийн тухай, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай, Ойн тухай, Зөрчлийн тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд холбогдох нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулна.

-----oOo-----

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны .. дугаар
сарын ..-ны өдөр

Улаанбаатар хот

БЭЛЧЭЭРИЙН ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь бэлчээрийг ашиглах, доройтлоос сэргийлэх, сайжруулах, хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл.Бэлчээрийн тухай хууль тогтоомж

2.1.Бэлчээрийн тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, Газрын тухай хууль, Газрын төлбөрийн тухай хууль, Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль, Ойн тухай хууль, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль, Төсвийн тухай хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан бусад хууль тогтоомжоос бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

3.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог доор дурдсанаар ойлгоно:

3.1.1.“бэлчээр” гэж мал, амьтан идээшлүүлэх зориулалттай байгалийн болон таримал бэлчээрийн ургамлын нөмрөг бүхий хөдөө аж ахуйн эдэлбэр газарт хамааруулсан газар нутгийг;

3.1.2.“хадлангийн талбай” гэж өвс бэлтгэх зориулалтаар ашиглах, газрын нэгдмэл сангийн ангилалд бүртгэгдсэн, байгалийн болон таримал ургамлын нөмрөг бүхий хөдөө аж ахуйн эдэлбэр газарт хамааруулсан газар нутгийг;

3.1.3.“отрын нөөц бэлчээр” гэж гамшиг, аюулт үзэгдлийн үед болон нүүдэллэн оторлож ашиглах зориулалтаар төрийн эрх бүхий байгууллагаас тусгайлан хилийн цэс, хэмжээ, байршил тогтоосон бүсийн газар нутгийг;

3.1.4.“нүүдэллэн оторлох бэлчээр” гэж мал ногоолуулах, тарга тэвээрэг авахуулах зориулалтаар ашиглалтгүй байгаа, зэлүүд бэлчээрт төрийн эрх бүхий байгууллагаас хилийн цэс тогтоож, тодорхой хугацаанд нүүдэллэн ашиглах бэлчээрийг;

3.1.5.“улирлын чанартай бэлчээр” гэж өвөлжөө, хаваржаа, зуслан болон намаржааны газар нутгийг;

3.1.6. “сайжруулсан бэлчээр” гэж хэт доройтсон болон эвдрэлд орсон талбайн хөрсний ус чийг, тэжээл, дулааны горимыг зохицуулж, ургац, шимт чанарыг нь нэмэгдүүлсэн бэлчээрийг;

3.1.7. “дамжин өнгөрөх бэлчээр” гэж отор, нүүдэл хийх болон мал, мах бэлтгэлийн зорилгоор тээвэр, туувар хийхэд зориулсан, эрх бүхий байгууллагаас баталсан зурвас газар нутгийг;

3.1.8. “таримал бэлчээр” гэж тариалангийн эргэлтийн талбайд болон атаршуулсан талбайд бэлчээрт ашиглах зорилгоор нэг ба олон наст ургамлыг тариалсан талбайг;

3.1.9. “бэлчээрийн нэгж талбар” гэж бэлчээр ашиглуулах гэрээ байгуулах зорилгоор эрх бүхий байгууллагаас хилийн цэсийг тогтоосон газар нутгийг;

3.1.10. “бэлчээрийн даац” гэж экологийн тэнцвэрт байдалд сөрөг нөлөө үзүүлэхгүйгээр бэлчээж болох мал, амьтны тоогоор илэрхийлэгдэх бэлчээрийн чадавхийг тогтоосон үзүүлэлтийг;

3.1.11. “нүүдлийн уламжлалт мал аж ахуй эрхлэх зориулалттай бэлчээр” гэж энэ хуулийн 3.1.3-3.1.6-д заасан бэлчээрийг;

3.1.12. “малчдын бүлэг” гэж Иргэний хуулийн 481.1-д заасны дагуу сайн дурын үндсэн дээр зохион байгуулалтад орсон, бэлчээрийн нэгж талбарыг хамтран ашиглахаар харилцан тохиролцож дүрмээ баталсан, хот айл, малчин өрхүүдийн хамтын зохион байгуулалтын нэгдлийг;

3.1.13. “малчдын бүлгийн дүрэм” гэж малчдын бүлгийн бүх гишүүдийн хурлаас баталсан, бэлчээр, усыг хамтран ашиглах, хамгаалах асуудал болон зохион байгуулалт, эрх, үүргийг тодорхойлсон баримт бичгийг;

3.1.14. “эрчимжсэн мал аж ахуй эрхлэх зориулалттай бэлчээр” гэж суурин болон хагас суурин хэлбэрийн мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэхэд ашиглах таримал, сайжруулсан болон зун, намрын улирлын бэлчээрийг;

3.1.15. “эрчимжсэн мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгч” гэж арвин ашиг шимт малыг суурин болон хагас суурин маллагааны хэлбэрээр өсгөн үржүүлж, түүнээс үр шимийг нь хүртэж байгаа иргэн, хуулийн этгээдийг;

3.1.16. “бэлчээр ашиглах” гэж бэлчээрийг төлөв байдал, даац, сэргэх чадавхийн түвшинд тохируулан, чанарыг нь доройтуулахгүйгээр хэрэглэх цогц үйл ажиллагааг;

3.1.17. “бэлчээр ашиглагч” гэж бэлчээр ашиглалтын гэрээ байгуулсан энэ хуулийн 3.1.12, 3.1.15-д заасан этгээдийг;

3.1.18. “бэлчээрийн доройтол” гэж төлөв байдлын анхны шинж чанараа алдсан, хөрсний үржил шим муудсан, бохирдсон, эвдрэлд орсон, элэгдэж талхлагдсан бэлчээрийн байдлыг;

3.1.19. “бэлчээрт учруулсан хохирол” гэж газрын нэгдмэл сангийн тайлангаар бэлчээр, хадлангийн газрын ангилалд байгаа бэлчээрийг хууль бусаар

ашигласан, эзэмшсэн, ашигт малтмалын хайгуул, олборлолт явуулсан, экологийн тогтолцоог алдагдуулсан, байгаль орчныг бохирдуулсан, бэлчээрийн даац хэтрүүлсэн, доройтуулсан, гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчсөний улмаас байгалийн баялаг, тэжээлийн нөөцөд хомсдол үүсгэн доройтолд хүргэсэн байдлыг;

3.1.20. “бэлчээр хамгаалах” гэж бэлчээрийн хөрс, үржил шим, ургамлын бүрэлдэхүүний төлөв байдал, чанарыг бууруулагч хүчин зүйлийг үнэлж тогтоох, хариу арга хэмжээг авах, хяналт тавих, бэлчээр доройтуулах үйл ажиллагааг зогсоох, эрсдлээс урьдчилан сэргийлэх цогц үйл ажиллагааг;

3.1.21. “бэлчээрийн төлөв байдлыг сайжруулах” гэж бэлчээрийг байгалийн жамаар болон хүний хүчин зүйлийн нөлөөллөөр нөхөн сэргээх цогц үйл ажиллагааг.

ХОЁРДУГААР БҮЛЭГ БЭЛЧЭЭРИЙН ЗОРИУЛАЛТ, АНГИЛАЛ

4 дүгээр зүйл. Бэлчээрийн зориулалт

4.1. Бэлчээрийг нүүдлийн уламжлалт болон эрчимжсэн мал аж ахуй эрхлэх зориулалтаар ашиглуулна.

4.2. Нийтийн ашиг сонирхолд сөргөөр нөлөөлөхөөс бусад тохиолдолд бэлчээрийн эдэлбэр газрыг өөр ангилалд шилжүүлэхгүй.

5 дугаар зүйл. Бэлчээрийн ангилал, төрөл

5.1. Бэлчээрийг зориулалтаар нь дараах байдлаар ангилна:

- 5.1.1. нийтээр ашиглуулах бэлчээр;
- 5.1.2. гэрээгээр ашиглуулах бэлчээр;

5.2. Нийтээр ашиглуулах бэлчээрт дор дурдсан бэлчээр хамаарна:

- 5.2.1. дамжин өнгөрөх бэлчээр;
- 5.2.2. байгалийн тогтцоор бий болсон гол, горхи, нуур, цөөрөм, уст цэг, хужир мараа бүхий зурвас газар.

5.3. Гэрээгээр ашиглуулах бэлчээрт дор дурдсан бэлчээр хамаарна:

- 5.3.1. улирлын чанартай бэлчээр;
- 5.3.2. отрын нөөц бэлчээр;
- 5.3.3. эрчимжсэн мал аж ахуйн зориулалттай бэлчээр;

5.4. Отрын нөөц бэлчээрт дор дурдсан бэлчээр хамаарна:

- 5.4.1. аймаг дундын отрын нөөц бэлчээр;
- 5.4.2. сум дундын отрын нөөц бэлчээр;
- 5.4.3. сумын отрын нөөц бэлчээр.
- 5.4.4. нүүдэллэн оторлох бэлчээр

5.5. Тусгай хамгаалалттай газар, хилийн зурвас газар, ой, усны сан бүхий газрын зөвшөөрөгдсөн бүсэд эрх бүхий байгууллагатай гэрээ байгуулсны үндсэн дээр заасан хугацаагаар мал бэлчээж болно.

ГУРАВДУГААР БҮЛЭГ БЭЛЧЭЭР АШИГЛАЛТЫН ГЭРЭЭ

6 дугаар зүйл.Бэлчээрийг нийтээр ашиглуулах

6.1.Нийтээр ашиглуулах бэлчээрийн байршил, хэмжээ, хилийн цэсийг газрын сангийн зураг, харьяалах баг, хорооны Иргэдийн Нийтийн Хурлын саналыг үндэслэж, бэлчээр нутгийн онцлогтой уялдуулан сум, мал бүхий дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тогтооно.

6.2.Улсын чанартай дамжин өнгөрөх бэлчээрийн хэмжээ, хилийн цэсийг газрын сангийн зурагт үндэслэн мал эмнэлгийн хорио цээрийн хяналтын цэгийн байршилтай уялдуулж, аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын саналыг авч Засгийн газар тогтооно.

6.3.Орон нутгийн чанартай дамжин өнгөрөх бэлчээрийн хэмжээ, хилийн цэсийг газрын сангийн зурагт үндэслэн мал тууврын замын чиглэлтэй уялдуулж, харьяалах сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын саналыг авч аймаг, нийслэлийн Засаг дарга тогтооно.

6.4.Энэ хуулийн 5.2, 5.4.3, 5.4.4-т заасан бэлчээрт мал оруулах, гаргах хуваарь болон харьяалах нутаг дэвсгэрээр нь дамжин өнгөрөх бэлчээрийг ашиглуулах журмыг тухайн баг, хорооны Иргэдийн Нийтийн Хурлын саналд үндэслэн сум, мал бүхий дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал баталж, хэрэгжилтэд хяналт тавина.

6.5.Дамжин өнгөрөх бэлчээр, тууврын замын чиглэлийг тогтоохдоо энэ хуулийн 8.1-д заасны дагуу гэрээ байгуулсан, мал оруулах, гаргах хуваарийн дагуу бэлчээрийг ашиглаж байгаа бэлчээр ашиглагчийн эрх ашгийг хохироосон шийдвэр гаргахгүй байна.

6.6.Нийтээр ашиглуулах бэлчээрийн төлөв байдал, чанарт үнэлгээ хийх, нөхөн сэргээх, бэлчээрийн бусад менежментийн үйл ажиллагааг зохион байгуулах арга хэмжээг тухайн сум, дүүргийн Засаг дарга хариуцна.

6.7.Нийтээр ашиглуулах бэлчээрт бэлчээр ашиглалтын гэрээ байгуулахгүй.

6.8.Нийтээр ашиглуулах бэлчээрт өвөлжөө, хаваржаа, хашаа саравч, барилга байгууламж барихыг хориглоно.

7 дугаар зүйл.Бэлчээрийг гэрээгээр ашиглуулах

7.1.Гэрээгээр ашиглуулах бэлчээрийн байршил, хэмжээ, хилийн цэсийг газрын сангийн зурагт үндэслэн бэлчээр нутгийн онцлог, харьяалах баг, хорооны Иргэдийн Нийтийн Хурлын саналыг харгалзан сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тогтооно.

7.2.Гэрээгээр ашиглуулах бэлчээрийг зориулалт, ангиллын дагуу холбогдох хүсэлт, шийдвэрийг үндэслэн дор дурьдсан этгээдэд бэлчээр ашиглалтын гэрээ /цаашид “гэрээ” гэх/ байгуулж, ашиглуулна:

7.2.1.малчдын бүлэгт улирлын чанартай бэлчээр болон эрх бүхий этгээдээс тодорхой хугацаанд ашиглуулахаар шийдвэрлэсэн отрын нөөц бэлчээрийн хэсгийг;

7.2.2.эрчимжсэн мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчид энэ хуулийн 3.1.14-т заасан бэлчээрийг;

7.3.Бэлчээрийг гэрээгээр ашиглагч нь нийтээр ашиглуулах бэлчээрийг ашиглахад энэ хуулийн 6 дугаар зүйлд заасныг баримтална.

7.4.Малчдын бүлгийн гишүүн нь улирлын чанартай бэлчээрийг ашиглахдаа түүний газар зүйн байршлаас хамаарч өөр малчдын бүлгийн гишүүнчлэлтэй байж болно.

7.5.Бэлчээр ашиглагчид нь сайн дураар нэгдэж, бэлчээр ашиглагчдын зөвлөл эсхүл холбоо байгуулан ажиллаж болно.

7.6.Гэрээгээр ашиглуулах бэлчээрийн ашиглалт, даацыг зохицуулах, хяналт тавих журмыг тухайн баг, хорооны Иргэдийн Нийтийн Хурлын саналд үндэслэн сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал баталж, хэрэгжилтэд хяналт тавина.

7.7.Эрчимжсэн мал аж ахуй эрхлэх зориулалтаар барилга, байгууламж барих, дэд бүтэц бий болгох тохиолдолд шаардлагатай газрыг Газрын тухай хуульд заасны дагуу шийдвэрлүүлнэ.

7.8.Эрчимжсэн мал аж ахуй эрхлэх бүс нутгийг аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрийг үндэслэн Засгийн газар тогтооно.

7.9.Гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээд, гадаадын иргэн, харьяалалгүй хүнтэй бэлчээр ашиглуулах гэрээ байгуулахгүй.

8 дугаар зүйл.Бэлчээрийг гэрээгээр ашиглах хүсэлт гаргах

8.1.Малчдын бүлэг нь энэ хуулийн 7.2.1-д заасан бэлчээрийг гэрээгээр ашиглах тухай хүсэлтээ харьяалах сум, дүүргийн хөдөө аж ахуйн тасагт гаргана.

8.2.Энэ хуулийн 8.1-д заасан хүсэлтэд дор дурдсан бичиг баримтыг хавсаргана:

8.2.1.малчдын бүлгийн дүрмийн хуулбар;

8.2.2.гишүүн өрх тус бүрийн жилийн эцэст тоологдсон өмчлөлийн болон гэрээ, хэлцлийн үндсэн дээр тавиулаар маллаж буй малын төрөл, тооны талаарх харьяалах баг, хорооны Засаг даргын тодорхойлолт;

8.2.3.гэрээгээр ашиглахаар хүсэлт гаргасан бэлчээрийн хилийн цэс, хэмжээ, уст цэг, хашаа, байгууламжийн байршлыг харуулсан тойм зураг;

8.2.4.гишүүн малчин өрх бүрийн гэр бүлийн гишүүдийн талаарх мэдээлэл, оршин суугаа хаягийн тодорхойлолт;

8.2.5.төлөөлөх эрх бүхий этгээдийг сонгосон талаарх малчдын бүлгийн хурлын шийдвэрийн хуулбар;

8.2.6.малчдын бүлэг саахалт малчдын бүлэг, хот айл, өрхтэй гэрээгээр ашиглах бэлчээрийн талаар харилцан тохиролцож, хилийн цэсийг тогтоосон талаар баталгаажуулсан баримт бичиг;

8.2.7.бэлчээрийг гэрээгээр ашиглуулах гэрээ байгуулахыг дэмжсэн харьяалах баг, хорооны Иргэдийн Нийтийн Хурлын шийдвэр;

8.2.8.гэрээгээр ашиглахаар хүсэлт гаргасан бэлчээрийн нэгж талбарыг ашиглах, хамгаалах, бэлчээрийн даацыг тохируулах төлөвлөгөөний төсөл.

8.3.Эрчимжсэн мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгч нь энэ хуулийн 7.2.2-т заасан бэлчээрийг гэрээгээр ашиглах тухай хүсэлтээ харьяалах сум, дүүргийн хөдөө аж ахуйн тасагт гаргана.

8.4.Энэ хуулийн 8.3-д заасан хүсэлтэд дор дурдсан бичиг баримтыг хавсаргана:

8.4.1.иргэн бол иргэний үнэмлэхийн, хуулийн этгээд бол улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;

8.4.2.өсгөн үржүүлж байгаа малын төрөл, тоо, ашиг шимийн чиглэл, сүргийн эргэлт, улирлаас хамааран тэдгээрт шаардагдах бэлчээр, хадлангийн өвс, ногоон тэжээлийн тоо хэмжээний тооцоолол;

8.4.3.гэрээгээр хариуцан ашиглах хүсэлт гаргасан байгаа зун, намрын болон таримал бэлчээрийн хэмжээ, хилийн цэс, малын байр, уст цэгийн байршлыг харуулсан тойм зураг;

8.4.4.хариуцан сайжруулж гэрээгээр ашиглах хүсэлт гаргасан бэлчээрийн нэгж талбарын байршил, хэмжээ, түүнийг ашиглах, хамгаалах, сайжруулах төлөвлөгөөний төсөл;

8.4.5.гэрээгээр ашиглах хүсэлт гаргасан бэлчээрийн хилийн цэсийн талаар хөрш зэргэлдээ, саахалт малчны бүлэг, хот айлтай харилцан тохиролцсон тухай бичгээр үйлдсэн баримт.

9 дүгээр зүйл.Бэлчээрийг гэрээгээр ашиглуулах шийдвэр гаргах

9.1.Сум, дүүргийн хөдөө аж ахуйн тасаг нь энэ хуулийн 8.1, 8.3-т заасан хүсэлтийг хүлээн авч бүртгэн, гэрээгээр ашиглах хүсэлт гаргасан бэлчээрийн байршил, хэмжээ, хилийн цэсийн талаар болон дор дурьдсан нөхцөл үүссэн эсэх талаар газрын мэдээллийн сангаас хяналт хийлгүүлэхээр газрын даамалд хүргүүлнэ:

9.1.1.ойн болон усан сан бүхий газар, тусгай хэрэгцээний болон зам, шугам сүлжээний газар, тэдгээрийн хамгаалалтын бүстэй давхцаж буй эсэх;

9.1.2.ашигт малтмалын ашиглалтын лицензи бүхий газартай давхцаж буй эсэх;

9.1.3.малчдын бүлгийн гишүүд, саахалт малчдын бүлэг, хот айлын гэрээгээр ашиглаж байгаа болон нийтээр ашиглуулах бэлчээртэй давхцаж байгаа эсэх.

9.2.Сум, дүүргийн газрын даамал хүсэлт гаргасан бэлчээрийн байршил, хилийн цэсийг нягтлан хянасан тухай дүгнэлтийг ажлын 14 хоногт багтаан гаргаж, хөдөө аж ахуйн тасгийн бэлчээрийн асуудал хариуцсан албан хаагчтай хамтран тухайн шатны Засаг даргад танилцуулна.

9.3. Сум, дүүргийн Засаг дарга нь энэ хуулийн 9.2-т заасан дүгнэлт, энэ хуульд заасан бусад шаардлагыг хангасан гэж үзвэл хүсэлт гаргасан этгээдтэй бэлчээр ашиглалтын гэрээ байгуулах тухай шийдвэр гаргана.

9.4. Энэ хуулийн 9.1-д заасан нөхцлийн аль нэг нь тогтоогдвол бэлчээр ашиглалтын гэрээг байгуулахгүй.

9.5. Сум, дүүргийн Засаг дарга бэлчээр ашиглалтын гэрээ байгуулахаас татгалзсан тохиолдолд хөдөө аж ахуйн тасаг үндэслэлийг тодорхой дурьдсан хариуг хүсэлт гаргагчид бичгээр өгнө.

10 дугаар зүйл. Бэлчээр ашиглалтын гэрээ байгуулах, гэрээг бүртгэх

10.1. Бэлчээр ашиглалтын гэрээг бэлчээрийн нэгж талбар бүрээр байгуулна.

10.2. Бэлчээр ашиглалтын гэрээний нийтлэг загварыг газрын болон хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.

10.3. Бэлчээр ашиглалтын гэрээнд малчдын бүлгийн насанд хүрсэн эмэгтэй, эрэгтэй гишүүд гарын үсэг зурж баталгаажуулах ба малчдын бүлгийн ахлагч малчин ерхийн үндэсний үйлдвэрлэгчийн баталгааны тэмдгийг хэрэглэнэ.

10.4. Бэлчээр ашиглалтын гэрээ байгуулах шийдвэр гарсан өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд багтаан сум, дүүргийн хөдөө аж ахуйн тасаг, газрын даамалтай хамтран энэ хуулийн 8.2.8, 8.4.4-т заасан төлөвлөгөө, гэрээгээр ашиглуулах бэлчээрийн байршил, хилийн цэсийг баталгаажуулна.

10.5. Энэ хуулийн 10.4-т заасан баталгаажуулалтын баримт нь бэлчээр ашиглалтын гэрээний салшгүй хэсэг байх ба гэрээний мэдээллийг газрын мэдээллийн санд болон сум, дүүргийн хөдөө аж ахуйн тасгийн мэдээллийн санд асуудал хариуцсан албан хаагч тухай бүрт бүртгэж байна.

10.6. Бэлчээр ашиглалтын гэрээг эхний удаа 5 жилээр байгуулж, гэрээний үүргийн биелэлтэд үндэслэн 15-40 жилийн хугацаатайгаар сунгана.

10.7. Бэлчээр зохион байгуулалт, ашиглалтын гэрээний хэрэгжилтэд сум, дүүргийн хөдөө аж ахуйн тасаг, газрын даамал хяналт тавих ба шаардлагатай тохиолдолд мэргэжлийн байгууллага, холбоодтой хамтран ажиллана.

11 дүгээр зүйл. Бэлчээр ашиглалтын гэрээг дүгнэх, сунгах, цуцлах, дуусгавар болгох

11.1. Бэлчээрийн даац, багтаамжийн тухайн жилийн хэмжээг сум, мал бүхий дүүргийн хөдөө аж ахуйн тасгаас тогтоох ба бэлчээрийн даац хэтэрсэн тохиолдолд дээрх хэмжээнд нийцүүлэн малын тоог бууруулах даалгавар, чиглэлийг өгч, энэ хуулийн 8.2.8-д заасан төлөвлөгөө, 10.1-д заасан гэрээнд тусгуулж, хэрэгжилтэд хяналт тавина.

11.2. Бэлчээрийн ургамлын зүйлийн бүтэц бүрэлдэхүүн, ургацын мониторингийн мэдээллийг үндэслэн гэрээт бэлчээрийн ачаалал, даац хэтэрсэн эсэх, бэлчээрийн төлөв байдалд гарсан өөрчлөлтийг гэрээ байгуулсны дараах жилээс эхлэн үнэлж, гэрээг дүгнэнэ.

11.3.Бэлчээр ашиглалтын гэрээний биелэлтийг талууд гэрээнд заасан хугацаанд дүгнэж, Засаг дарга баталгаажуулна.

11.4.Бэлчээр ашиглагч нь гэрээний хугацаа дуусгавар болохоос 60-аас доошгүй хоногийн өмнө гэрээ сунгуулах хүсэлт, гэрээний биелэлтийн тайланг сум, дүүргийн хөдөө аж ахуйн тасагт ирүүлнэ.

11.5.Сум, дүүргийн хөдөө аж ахуйн тасаг нь энэ хуулийн 11.4-т заасан хүсэлтийг хүлээж авсан өдрөөс хойш ажлын 14 хоногийн дотор бэлчээр ашиглагчийн гэрээгээр хүлээсэн үүргийн биелэлтийг хянан дүгнэлт гаргаж, Засаг даргад танилцуулна.

11.6.Сум, дүүргийн Засаг дарга энэ хуулийн 11.5-д заасан дүгнэлтийг үндэслэн гэрээг сунгах эсэх талаарх шийдвэрийг ажлын 5 хоногийн дотор гаргана.

11.7.Бэлчээр ашиглагч нь гэрээгээр хүлээсэн үүргээ удаа дараа, эсхүл ноцтой зөрчсөн, гэрээгээр хүлээсэн үүргээ хангалтгүй биелүүлсэн нь тогтоогдвол бэлчээр ашиглагчтай байгуулсан гэрээг цуцлах, дуусгавар болгох асуудлыг сум, дүүргийн Иргэдийн Нийтийн хурлаар хэлэлцүүлж, харьяалах шатны Засаг дарга шийдвэр гаргана.

11.8.Бэлчээр ашиглалтын гэрээг дараах тохиолдолд сум, дүүргийн Засаг даргын санаачлагаар хугацаанаас нь өмнө цуцална:

11.8.1.гэрээнд ашиглуулахаар заасан бэлчээрийг зориулалтын дагуу ашиглаагүй;

11.8.2.гэрээнд ашиглуулахаар заасан бэлчээрийг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр 2 жил дараалан ашиглаагүй;

12 дугаар зүйл.Отрын нөөц бэлчээрийг ашиглуулах

12.1.Монгол Улсын нийт бэлчээрийн 10-аас доошгүй хувь нь отрын нөөц бэлчээр байна.

12.2.Отрын нөөц бэлчээрийн хэмжээ, хилийн цэсийг хамаарах нутаг дэвсгэрийн бэлчээр ашиглагчдын санал, багийн иргэдийн Нийтийн Хурлын шийдвэр, тухайн шатны Засаг даргын саналыг тус тус үндэслэн дор дурдсан этгээд тогтооно:

12.2.1.аймаг дундын отрын нөөц бэлчээрийн хэмжээ, хилийн цэсийг Засгийн газар;

12.2.2.сум дундын отрын нөөц бэлчээрийн хэмжээ, хилийн цэсийг харьяалах аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал;

12.2.3.сумын отрын нөөц бэлчээрийн болон нүүдэллэн оторлох бэлчээрийн хэмжээ, хилийн цэсийг харьяалах сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал.

12.3.Бэлчээрийг отрын нөөц бэлчээрт авах тухай шийдвэрийг эрх бүхий этгээд гаргахдаа тухайн нутагт нутаглаж байгаа болон гэрээгээр ашиглаж байгаа бэлчээр ашиглагчийн эрх ашгийг хохироосон шийдвэр гаргахгүй.

12.4.Отрын нөөц бэлчээрийн хэмжээ, байршлын мэдээллийг дор дурдсан байгууллага газрын нэгдмэл сангийн мэдээллийн сангийн тайланд тусгаж байна.

12.4.1.сумын отрын нөөц бэлчээрийг тухайн сумын газрын даамал;

12.4.2.сум дундын отрын нөөц бэлчээрийг тухайн аймгийн газрын даамал;

12.4.3.аймаг дундын отрын нөөц бэлчээрийг энэ хуулийн 18.4-т заасан төрийн үйлчилгээний байгууллага.

12.5.Аймаг дундын отрын нөөц бэлчээрийг ашиглуулах журмыг хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, сум дундын отрын нөөц бэлчээрийг ашиглуулах журмыг тухайн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, сумын отрын нөөц бэлчээр болон нүүдэллэн оторлох бэлчээрийг ашиглуулах журмыг тухайн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тус тус батална.

12.6.Отрын нөөц бэлчээрт мал оруулах, бэлчээрээс гаргах асуудлыг дор дурдсан этгээд шийдвэрлэнэ:

12.6.1.аймаг дундын отрын нөөц бэлчээрт тухайн аймгийн Засаг даргатай зөвшилцөн хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн;

12.6.2.сум дундын отрын нөөц бэлчээрт харьяалах аймгийн Засаг дарга;

12.6.3.сумын отрын нөөц бэлчээрт болон нүүдэллэн оторлох бэлчээрт харьяалах сумын Засаг дарга.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ БЭЛЧЭЭРИЙГ ҮНЭЛЭХ, ХАМГААЛАХ

13 дугаар зүйл.Бэлчээрийн төлөв байдлыг үнэлэх

13.1.Бэлчээр ашиглалтын гэрээний хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулахдаа ус, цаг уур орчны хяналт болон газрын харилцааны сүлжээн дэх бэлчээрийн төлөв байдлын мониторингийн жил бүрийн мэдээлэл, төлөв байдлын үнэлгээнд суурилна.

13.2.Бэлчээрийн төлөв байдал, чанарын хянан баталгааны үнэлгээ, дүрсжүүлсэн хяналт шинжилгээний дүгнэлтийг үндэслэн бэлчээр ашиглуулах гэрээг байгуулах, сунгах, бэлчээрийг сайжруулах, хамгаалах арга хэмжээг бүх шатны Засаг дарга авч хэрэгжүүлнэ.

13.3.Бэлчээрийн доройтлын зэрэглэлийг Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хуулийн 5 дугаар зүйлд заасны дагуу тогтооно.

13.4.Энэ хуулийн 18.4-д заасан байгууллага нь бэлчээрийн төлөв байдал, чанарын хянан баталгааны үнэлгээний тайлан, дүрсжүүлсэн хяналт шинжилгээний дүн шинжилгээ, гэрээгээр ашиглуулсан бэлчээрийн бүртгэлийн мэдээлэл, бэлчээрийн даац, хангамжийн тооцооллыг нэгтгэж, бэлчээрийн мэдээллийн санг бүрдүүлнэ.

13.5.Бэлчээрийн даац, хангамжийн түвшинг тогтоох аргачлал, бэлчээрийн мэдээллийн сан бүрдүүлэх, ашиглах журмыг хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

13.6.Доройтсон бэлчээрийн нөхөн сэргэх чадавхийн ангилал тооцох аргачлалыг хөдөө аж ахуйн болон байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

14 дүгээр зүйл.Бэлчээрийг доройтлоос сэргийлэх, сайжруулах, хамгаалах

14.1.Бэлчээр ашиглагч нь энэ хуулийн 17.1-д заасан төлөвлөгөөний дагуу дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ:

- 14.1.1.бэлчээрийн даац хэтрүүлэхгүй байх;
- 14.1.2.бэлчээр, хадлангийн нөөцийг шавхахгүй байх;
- 14.1.3.доройтсон бэлчээрт ургамал төлжин ургах нөхцөл бүрдүүлэх;
- 14.1.4.малаа сэлгэн бэлчээх.

14.2.Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нь орон нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжлийн түвшин, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн онцлог, газар зүйн бүсчлэлтэй уялдуулан бэлчээрийн даацад нийцүүлэн ашиглалтыг зохицуулах, доройтлоос сэргийлэх, нөхөн сэргээх, бэлчээрийн зориулалттай барилга байгууламжийн дэд бүтцийг сайжруулахтай холбогдсон дэд хөтөлбөр хэрэгжүүлнэ.

14.3.Нийтээр ашиглах бэлчээрийг ашиглуулах, сайжруулах, хамгаалахтай холбоотой үйл ажиллагааг харьяалах нутаг дэвсгэрт сум, дүүргийн Засаг дарга хариуцан хэрэгжүүлнэ.

14.4.Гэрээгээр ашиглаж байгаа бэлчээрийг зохистой ашиглах, сайжруулах, хамгаалах үйл ажиллагааг бэлчээр ашиглагч хариуцна.

14.5.Доройтолд орсон, зэлүүд ашиглалтгүй байгаа бэлчээрт хөрөнгө оруулалт хийж ашиглах нөхцөлийг бүрдүүлсэн, өмнөх төлөв байдлыг сайжруулсан бэлчээр ашиглагчид тухайн бэлчээрийг давуу эрхтэйгээр гэрээгээр ашиглуулж болно.

14.6.Бэлчээрт авто зам гаргах, бэлчээрийн хөрсийг эвдэх, бохирдуулах, бусад байдлаар бэлчээрийн төлөв байдлыг алдагдуулах болон цөл, цөлөрхөг хээрийн бүсэд эсхүл хөрсний эвдрэл, цөлжилт үүсэх эрсдэл бүхий бэлчээрт ургамал түүх, хадлан бэлтгэхийг хориглоно.

15 дугаар зүйл.Бэлчээр ашигласны төлбөр

15.1.Бэлчээр ашиглагч нь бэлчээрийн ангилал, бүс нутгийн онцлог, малын төрлийн ялгавартай уялдуулж, бэлчээр ашигласны төлбөр төлнө.

15.2.Бэлчээр ашигласны төлбөрийн хэмжээг Газрын төлбөрийн тухай хуулиар зохицуулна.

16 дугаар зүйл.Бэлчээрт учруулсан хохирол тооцох, нөхөн төлбөр төлөх

16.1.Бэлчээр ашиглагч нь энэ хуулийн 19.2.4-т заасан үүргээ биелүүлээгүй бол бэлчээрийн даацаас хэтэрсэн нийт малын зах зээлийн үнэлгээтэй дүйцэхүйц хэмжээгээр учирсан хохирлыг төлүүлнэ.

16.2.Ашигт малтмалын хайгуул, ашиглалттай холбоотойгоор бусдын гэрээгээр ашиглаж байгаа бэлчээр, хадлангийн талбайд хохирол учруулбал тусгай зөвшөөрөл эзэмшигч нь хохирлыг нөхөн төлнө.

16.3.Газар тариалангийн үйлдвэрлэлийн үйл ажиллагаанаас шалтгаалж бусдын гэрээгээр ашиглаж, эзэмшиж байгаа бэлчээр, хадлангийн талбайд учруулсан хохирлыг тэргүүн ээлжинд тухайн үйлдвэрлэл эрхлэгч нөхөн төлнө.

16.4.Давагдашгүй хүчин зүйлийн нөлөөллөөс бусад шалтгаанаар бусдын гэрээгээр ашиглаж, эзэмшиж байгаа бэлчээр, хадлангийн талбайд түймэр гарч, хохирол учруулбал буруутай этгээд холбогдох хуулийн дагуу хариуцлага хүлээсэн эсэхээс үл хамаарч хохирлыг нөхөн төлнө.

16.5.Бусдын гэрээгээр ашиглаж байгаа бэлчээрийг дайран өнгөрөхдөө учруулсан хохирлыг буруутай этгээд нөхөн төлнө.

16.6.Нийтээр ашиглах болон отрын бэлчээрийг ашиглах журам зөрчсөний улмаас учруулсан хохирлыг буруутай этгээд нөхөн төлнө.

16.7.Бэлчээр ашиглагчийн орон байр болон бэлчээрийн зориулалттай дэд бүтцэд учруулсан хохирлыг гэм буруутай этгээд бэлчээрт учруулсан хохирлыг нөхөн төлсөн эсэхээс үл хамаарч хариуцан арилгах үүрэгтэй.

16.8.Бэлчээрт учруулсан хохирол тооцох аргачлал, нөхөн төлбөр төлөх журмыг хөдөө аж ахуйн болон санхүүгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

ТАВДУГААР БҮЛЭГ БЭЛЧЭЭР АШИГЛАХ, ХАМГААЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

17 дугаар зүйл.Бэлчээрийг ашиглах, сайжруулах, хамгаалах үйл ажиллагааг төлөвлөх

17.1.Аймаг, нийслэл, сум, мал бүхий дүүрэг нь бэлчээр, хадлангийн газар зохион байгуулалт, ашиглалт, хамгаалалтын жилийн болон дунд хугацааны төлөвлөгөө /цаашид “төлөвлөгөө” гэх/-тэй байна

17.2.Төлөвлөгөөг бэлчээр ашиглагчдын саналыг авч, хэлэлцүүлсний үндсэн дээр тухайн шатны Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал батлах ба дор дурдсан үзүүлэлтийг шалгуур болгоно:

17.2.1.бэлчээрийн геоботаникийн судалгааны үр дүн;

17.2.2. баг, хороо, иргэн, хуулийн этгээдийн малын тоо, төрөл;

17.2.3.нас, хүйс, төрлөөр ангилсан сүргийн бүтэц, оторлох, тууварлах малын тоо;

17.2.4.баг, хорооны иргэдийн Нийтийн Хурлын санал, дүгнэлт;

17.2.5.шаардлагатай тохиолдолд мэргэжлийн холбоодын санал.

17.4.Энэ хуулийн 17.1-д заасан төлөвлөгөө нь аймаг, нийслэл, сум, дүүргийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний бүрэлдэхүүн хэсэг байх ба энэ

төлөвлөгөөнд орон нутгийн онцлогийг харгалзан дараах бичиг баримтыг хавсаргана:

17.4.1.бэлчээрийн нийт талбайн кадастрын зураг;

17.4.2.мал услах усны эх үүсвэрийн байршлын зураглал;

17.4.3.улирлаар сэлгэж ашиглах нийт бэлчээрийн хилийн цэс, хэмжээ, улирлын хуваарь, байршлын зураглал;

17.4.4.отрын нөөц бэлчээрийн хилийн цэс, хэмжээ, тэмдэглэгээний байдал;

17.4.5.гэрээт бэлчээрийн нэгж талбар тус бүрийн хилийн цэс, хэмжээ, байршлын бүдүүвч зураг, бэлчээрийн ачаалал, даацын талаар мэдээлэл;

17.4.6.нүүдэллэн оторлох бэлчээрийн байршлын бүдүүвч зураглал;

17.4.7.сэргэх чадавх, даацад нь тохируулан ашиглах бэлчээрийн хилийн цэс, хэмжээ, байршлын зураглал;

17.4.8.төлөв байдал, чанарыг байгаа түвшинд хадгалах бэлчээр, хадлангийн газрын хилийн цэс, хэмжээ, байршлын зураглал;

17.4.9.хөрсний үржил шимийг сайжруулах, элэгдлийг бууруулах бэлчээрийн хилийн цэс, хэмжээ;

17.4.10.ургамлын бүтэц, бүрэлдэхүүнийг нөхөн сэргээх бэлчээрийн хилийн цэс, хэмжээ, байршлын зураглал;

17.4.11.усан хангамжийн хүрэлцээг сайжруулах бэлчээрийн хэмжээ;

17.4.12.шинээр өвөлжөө, хаваржаа барих, нөөц бэлчээрийн байршил, тоймчилсон хуваарийн зураглал;

17.4.13.гэрээний хугацаа сунгасан болон гэрээ хүчингүй болсон бэлчээрийн хилийн цэс, хэмжээ, байршлын зураглал;

17.4.14.бэлчээрийн дэд бүтэц, ангиллын өөрчлөлтийн төлөв.

18 дугаар зүйл.Бэлчээр ашиглуулах үйл ажиллагаанд төрийн байгууллагын эрх,чиг үүрэг

18.1.Улсын Их Хурал болон Засгийн газар нь бэлчээрийг ашиглах, доройтлоос сэргийлэх, сайжруулах, хамгаалах үйл ажиллагаанд энэ хуульд болон Газрын тухай хуульд заасан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

18.2.Бэлчээрийг ашиглах, доройтлоос сэргийлэх, сайжруулах, ашиглах, хамгаалах талаарх төрийн бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохицуулах, зохион байгуулах чиг үүргийг улсын хэмжээнд хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэлд хөдөө аж ахуйн асуудал хариуцсан байгууллага, сум, мал бүхий дүүрэгт хөдөө аж ахуйн тасаг тус тус хариуцан гүйцэтгэнэ.

18.3.Хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь дараах үйл ажиллагааг хариуцан хэрэгжүүлнэ:

18.3.1.бэлчээр ашиглах, доройтлоос сэргийлэх, сайжруулах, хамгаалах хөгжлийн бодлогыг боловсруулах, төлөвлөх, бодлогын хэрэгжилтийг зохицуулах;

18.3.2.бэлчээрийн төлөв байдал, чанарын судалгаа, хянан баталгаа хийх ажлыг холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулах;

18.3.3.нийтийн ашиг сонирхлын үүднээс бэлчээрийг газрын нэгдмэл сангийн өөр ангилалд шилжүүлэх эсхүл бэлчээрийг хөдөө аж ахуйн газрын доторх бусад дэд ангилалд шилжүүлэх талаарх үндэслэл, тооцоог судалж, санал дүгнэлтээ эрх бүхий байгууллагад хүргүүлэх;

18.3.4.бэлчээрийг зохистой ашиглах, хамгаалахтай холбогдсон салбар дундын зохицуулалтыг хариуцан зохион байгуулах;

18.3.5.бэлчээрийн зориулалттай дэд бүтцийн барилга, байгууламжийн хэрэгцээг тодорхойлж, шаардлагыг тогтоох, төлөвлөх, хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих;

18.3.6.малын тоог бэлчээрийн даацад нийцүүлэх, чанар ашиг шимийг нэмэгдүүлэх эдийн засгийн сонирхлын хөшүүргийг нэвтрүүлэх, дэмжих, урамшуулах бодлогыг хэрэгжүүлэх;

18.3.7.аймаг дундын отрын бэлчээрийг ашиглах, хамгаалах төлөвлөгөөг батлах, хэрэгжилтэд хяналт тавих;

18.3.8.бэлчээрийг зохистой ашиглах, хамгаалах талаар бэлчээр ашиглагчдыг мэргэжил, арга зүйн зөвлөгөө, мэдээллээр хангах;

18.3.9.хуульд заасан бусад.

18.4.Хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын харьяанд бэлчээр, хадлангийн эдэлбэр газрын мэдээллийн дэд санг бүрдүүлэх, улсын тусгай хэрэгцээний отрын нөөц бэлчээрийн ашиглалт, хамгаалалтад хяналт тавих чиг үүрэг бүхий төрийн байгууллага байна.

18.5.Энэ хуулийн 18.4-т заасан байгууллага нь мэргэжлийн холбоод, салбарын төрийн бус байгууллага, сургалт, эрдэм шинжилгээний байгууллага, бэлчээр ашиглагчдын төлөөллөөс бүрдсэн бэлчээрийн асуудлаар зөвлөх чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөл /цаашид "Зөвлөл" гэх/-тэй байна.

18.6.Энэ хуулийн 18.4-т заасан байгууллага нь дараах чиг үүрэгтэй:

18.6.1.энэ хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах;

18.6.2.бэлчээрийн төлөв байдал, ургамлын бүрэлдэхүүн, ургамлын бүрхэвчийн өөрчлөлт, ашиглалтад хяналт шинжилгээ, дүрсжүүлсэн үнэлгээ хийх үйл ажиллагааг зохион байгуулах;

18.6.3.бэлчээрийн төлөв байдал, чанар, ашиглалт, хамгаалалттай холбоотой мэдээллийн санг бүрдүүлэх, нэмэлт, өөрчлөлтийг тусгаж байх ажлыг газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай хамтран зохион байгуулах, хэрэгжилтийг хангах;

18.6.4.аймаг дундын отрын бэлчээрийн ашиглалт, хамгаалалтын заагийг тэмдэгжүүлэх, бэлчээрийн даац, хашаа хороо, уст цэгийн байршлын зураглалын өөрчлөлтийг тогтмол хянах ажлыг зохион байгуулах;

18.6.5.аймаг дундын отрын бэлчээрийн зохион байгуулалтын төлөвлөгөө, бэлчээрийн төлөв байдлын үнэлгээнд үндэслэн отрын нөөц бэлчээрт тухайн жилд өвөлжих, хаваржих өрх, малын тоог тогтоох, отор нүүдлийг зохион байгуулах, зохицуулах;

18.6.6.аймаг дундын отрын нөөц бэлчээрийг ашиглах зөвшөөрөл олгох, өвөлжөө, хаваржаа, худаг, уст цэгийг хуваарилах, бэлчээр ашиглах хамгаалах талаар холбогдох гэрээг байгуулах, сум, дүүргийн Засаг даргын хүлээсэн үүргийн хэрэгжилтэд хяналт тавих, мэргэжил арга зүйгээр хангах;

18.6.7.аймаг дундын отрын нөөц бэлчээрт малын гоц халдварт болон халдварт өвчин гарахаас урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх арга хэмжээг холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулах;

18.6.8.аймаг дундын отрын нөөц бэлчээрт шаардлагатай малын хашаа, хороо, уст цэг, өвс тэжээлийн аюулгүйн нөөц бүрдүүлэх;

18.6.9.аймаг дундын отрын нөөц бэлчээрийг хөнөөлт шавьж, мэрэгчээс сэргийлэх, тэмцэх, хамгаалах, бэлчээрийг усжуулах, нөхөн сэргээх, сайжруулах, худаг, уст цэг шинээр гаргах, засварлах арга хэмжээг зохион байгуулах;

18.6.10.бэлчээрийг зохистой ашиглах, хамгаалах талаарх судалгаа ба хөгжлийн төслийг санаачлах, холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллах, хэрэгжүүлэх.

18.7.Энэ хуулийн 18.4-т заасан байгууллагын бүтэц, орон тоо, үйл ажиллагааны хөтөлбөр, 18.5-д заасан Зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах дүрмийг хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

18.8.Бэлчээрийг гэрээгээр ашиглуулахад сум, мал бүхий дүүргийн Засаг дарга дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

18.8.1.бэлчээр ашиглагчдын болон тухайн баг, хорооны Иргэдийн нийтийн хурлын саналыг харгалзан нийтээр ашиглах бэлчээр болон хадлангийн талбайд мал оруулах, гаргах, хадлан хадах хугацаа, өнжөөх тухай шийдвэрийг гаргах, хэрэгжилтэд хяналт тавих;

18.8.2.байгалийн гамшиг, гэнэтийн аюулын улмаас өөр аймаг, сумын нутаг дэвсгэрт нүүдэл хийх эсхүл харьяалах нутаг дэвсгэрт гаднаас мал оруулах асуудлыг бэлчээрийн даацад нийцүүлж тухайн засаг захиргааны нэгжийн удирдлага, гэрээ байгуулсан этгээдтэй харилцан тохиролцож, шийдвэрлэх;

18.8.3.бэлчээр ашиглагчийн энэ хуулийн 19.1-д заасан эрхээ эдлэх нөхцөлийг хангах;

18.8.4.харьяалах нутаг дэвсгэрээр мал дамжин өнгөрөх болон бусдын гэрээгээр эзэмшиж, ашиглаж байгаа бэлчээрийг дайран өнгөрөхөд баримтлах журмыг батлах;

18.8.5.энэ хуульд болон холбогдох бусад хууль тогтоомж, салбарын урт, дунд хугацааны бодлого, зорилгод заасан бэлчээрийн менежментийн арга хэмжээг зохион байгуулах, хэрэгжилтийг хангах.

18.9.Энэ хуулийн 18.8-д заасан үйл ажиллагааг тухайн шатны Засаг дарга хариуцан хэрэгжүүлэхдээ бэлчээрийн үйл ажиллагаанд оролцогч талуудын төлөөллөөс бүрдсэн орон тооны бус Зөвлөлийг ажиллуулж болно.

18.10.Энэ хуулийн 18.9-д заасан зөвлөлийн ажиллах журмыг сум, мал бүхий дүүргийн хөдөө аж ахуйн тасаг хариуцан боловсруулж, Засаг дарга батална.

19 дүгээр зүйл. Бэлчээр ашиглагчийн нийтлэг эрх, үүрэг

19.1.Бэлчээр ашиглагч нь дараах нийтлэг эрх эдэлнэ:

19.1.1.гэрээгээр ашиглаж байгаа бэлчээрийг бусад этгээд зөвшөөрөлгүй, дур мэдэн ашигласан тохиолдолд уг үйлдлийг зогсоохыг шаардах, шаардлага биелүүлээгүй тохиолдолд эрх бүхий байгууллага, албан тушаалтанд гомдол гаргах;

19.1.2.бэлчээрт учруулсан аливаа хохирлыг тогтоолгох, нөхөн төлүүлэх;

19.1.3.малчдын бүлэгт орох, малчдын бүлгээс гарах;

19.1.4.бэлчээрийг гэрээний дагуу ашиглах;

19.1.5.давагдашгүй хүчин зүйлийн улмаас бусдын гэрээгээр ашиглаж байгаа бэлчээрт эрх бүхий этгээдээс баталсан хуваарийн дагуу мал оруулах, гаргах.

19.2.Бэлчээр ашиглагч нь дараах нийтлэг үүргийг хүлээнэ:

19.2.1.гэрээнд заасан үүргээ биелүүлэх;

19.2.2.бэлчээрийн даацад малын тоог нийцүүлэх;

19.2.3.бэлчээр ашигласны төлбөрийг тогтоосон хэмжээгээр төлөх;

19.2.4.бэлчээрийн даацаас шалтгаалан малын тоог бууруулах нөхцөл байдал үүссэн тохиолдолд үе шаттай шийдвэрлэх арга хэмжээг энэ хуулийн 11.1-д заасны дагуу авч хэрэгжүүлэх;

19.2.5.эрх бүхий этгээдээс баталсан бэлчээр сэлгэх, өнжөөх, улирлаар нүүх хугацааг мөрдөх;

19.2.6.өвөлжөө, хаваржааны бэлчээрт зун, намрын улиралд мал оруулахгүй хамгаалах, бэлчээрийг арчлан тордох;

19.2.7.уламжлалт мал аж ахуй эрхлэх зориулалттай бэлчээрийн хилийн цэс, дамжин болон дайран өнгөрөх нүүдлийн зам, зэрлэг ан, амьтны шилжилт хөдөлгөөнд саад учруулж хашихгүй, суваг, шуудуу ухахгүй байх;

19.2.8. хөрш болон саахалт малчдын бүлэг, бусад малчин өрхийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх;

19.2.9.өөрийн буруутай үйл ажиллагааны улмаас бэлчээрт учруулсан хохирлыг нөхөн төлөх;

19.2.10.бэлчээрийн хөрсийг эвдэхгүй, бэлчээрийн хөрс, усыг бохирдуулахгүй, хог хаягдал хаяхгүй байх;

19.2.11.бэлчээрт авто зам гаргахгүй байх;

19.2.12.давагдашгүй хүчин зүйлийн улмаас нүүдэл хийх тохиолдолд гэрээгээр ашиглаж байгаа бэлчээрт мал оруулах, гаргах;

19.2.13.бусдын гэрээгээр ашиглаж байгаа бэлчээрийг дайран өнгөрөхдөө хохирол учруулахгүй байх;

19.2.14.хууль тогтоомжид заасан бусад үүрэг.

20 дугаар зүйл.Бэлчээр ашиглах, сайжруулах, хамгаалах үйл ажиллагаанд мэргэжлийн холбоодын оролцоо

20.1.Энэ хуулийн нь 7.5-д заасан этгээд болон мэргэжлийн бусад төрийн бус байгууллага нь дор дурдсан чиг үүргийг хэрэгжүүлнэ:

20.1.1.бэлчээрийн зохион байгуулалтыг оновчтой явуулахад мэргэжлийн дэмжлэг, туслалцаа, үйлчилгээ үзүүлэх;

20.1.2.бэлчээрийн даацыг тогтоох, үнэлэх, сайжруулах, хамгаалах чиглэлийн ажил, үйлчилгээг сум, дүүргийн Засаг даргатай байгуулсан гэрээний үндсэн дээр гүйцэтгэх;

20.1.3.энэ хуулийн 17.1-д заасан төлөвлөгөөг боловсруулахад мэргэжлийн зөвлөмж, арга зүйн удирдамжаар хангах, хэрэгжилтэнд хөндлөнгийн хяналт тавих;

20.1.4.бэлчээрийг ашиглах, доройтсон бэлчээрийг сайжруулах, хамгаалахтай холбогдсон асуудлаар төрийн байгууллагад санал, хүсэлт, зөвлөмж хүргүүлэх;

20.1.5.бэлчээрийн менежментийн бусад үйл ажиллагааг зохион байгуулахад оролцох, холбогдох аргачлал, журмын төсөл, саналыг боловсруулж, эрх бүхий байгууллагад хүргүүлэх, хэрэгжүүлэхэд мэргэжлийн зөвлөмж, арга зүйгээр хангах;

20.1.6.бэлчээр ашиглагчдыг мэдлэгжүүлэх сургалт, сурталчилгааг зохион байгуулах.

ЗУРГААДУГААР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ

21 дүгээр зүйл. Бэлчээр ашиглах, сайжруулах, хамгаалах үйл ажиллагааны санхүүжилт

21.1.Бэлчээрийг ашиглах, сайжруулах, хамгаалах үйл ажиллагааны санхүүжилт дараах эх үүсвэрээс бүрдэнэ:

21.1.1.улсын болон орон нутгийн төсөв;

21.1.2.бэлчээр ашигласны төлбөрийг төвлөрүүлсэн хөрөнгө;

21.1.3.бүсийн болон олон улсын байгууллагын хамтын ажиллагааны оролцооны санхүүжилт;

21.1.4.бусад эх үүсвэр.

21.2. Бэлчээрийг ашиглах, сайжруулах, хамгаалах үйл ажиллагааны дараах зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ:

21.2.1.бэлчээр, хадлангийн эдэлбэр газрын бүртгэл, мэдээллийн санг бүрдүүлэх, ажиллуулах;

21.2.2.бэлчээрийн төлөв байдлыг тодорхойлох, үнэлэх;

21.2.3.аймаг дундын отрын нөөц бэлчээрийн судалгаа, үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, хэрэгжүүлэх;

21.2.4.бэлчээрийн хөнөөлт шавж, хортон мэрэгчтэй тэмцэх;

21.2.5.бэлчээрийн уст цэгт шинээр хайгуул хийх;

21.2.6.бэлчээрийг нөхөн сэргээх, сайжруулах зориулалтаар олон наст таримал ургамлын үр сорт бий болгоход дэмжлэг үзүүлэх

21.3.Орон нутгийн төсвөөс болон энэ хуулийн 21.1.2-т заасан хөрөнгөөс дараах арга хэмжээг санхүүжүүлнэ:

21.3.1.бэлчээр, хадлангийн газрын тухайн жилийн ургац, даацыг тогтоох;

21.3.2.бэлчээрийн менемент хийх, бэлчээрийн даацыг тохируулах, бэлчээрийг доройтлоос сэргийлэх, сайжруулах, хамгаалах, мал аж ахуйг хөгжүүлэх;

21.3.3.хадлан, тэжээл бэлтгэх зориулалттай техник, технологийн шинэчлэл хийх, худаг сэргээн засварлах;

21.3.4.бэлчээрийн зохион байгуулалт, ашиглалт, хамгаалалтын үйл ажиллагааны болон технологийн чиглэлийн сургалтыг зохион байгуулах, сурталчлах;

21.4.Бэлчээрийг ашиглах, сайжруулах, хамгаалах үйл ажиллагааны дараахь зардлыг бэлчээр ашиглагч хариуцан санхүүжүүлнэ:

21.4.1.бэлчээр ашигласны төлбөр;

21.4.2.ашиглалтын гэрээ байгуулсан бэлчээрийн нэгж талбарыг зохистой ашиглах сайжруулах, хамгаалах арга хэмжээний зардал;

21.4.3.хууль, тогтоомжид заасан бусад зардал.

22 дугаар зүйл.Маргаан шийдвэрлэх

22.1.Бэлчээрийг ашиглахтай холбогдон гарсан бэлчээр ашиглагчдын маргааныг маргалдагч талууд хоорондоо харилцан тохиролцон шийдвэрлэнэ.

22.2.Бэлчээр ашиглагч болон холбогдох албан тушаалтны хооронд гарсан маргааныг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

22.3.Бэлчээрийг ашиглах, сайжруулах, хамгаалах харилцаанд гарсан аливаа маргаан, гомдлыг энэ хуулийн 22.1-22.2-т заасны дагуу шийдвэрлэх боломжгүй тохиолдолд уг асуудлыг шүүхээр шийдвэрлүүлнэ.

23 дугаар зүйл.Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

23.1.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

23.2.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

24 дүгээр зүйл.Хууль хүчин төгөлдөр болох

24.1.Энэ хуулийг оны ... дугаар сарын ... -ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

БЭЛЧЭЭРИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ДАГАЛДАХ ХУУЛИЙН ТӨСЛҮҮД

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны ... дугаар
сарын ... –ны өдөр

Улаанбаатар хот

ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

“1 дүгээр зүйл.Татварын ерөнхий хуулийн 7.4 дэх хэсэгт доор дурдсан агуулгатай 7.4.19 дэх заалт нэмсүгэй:

“1/7.4.19.бэлчээр ашигласны төлбөр.”

2 дугаар зүйл.Татварын ерөнхий хуулийн 8.5 дахь хэсгийн “7.4.16” гэсний дараа “7.4.19” гэж нэмсүгэй.

3 дугаар зүйл.Энэ хуулийг Бэлчээрийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.”

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны ... дугаар
сарын ... –ны өдөр

Улаанбаатар хот

ХУВЬ ХҮНИЙ ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

“1 дүгээр зүйл. Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 16.1.13 дахь хэсэг заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Бэлчээрийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.”

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны ... дугаар
сарын ... –ны өдөр

Улаанбаатар хот

ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

“1 дүгээр зүйл.Төсвийн тухай хуулийн 23.8 дахь хэсэгт доор дурдсан агуулгатай 23.8.14 дэх заалт нэмсүгэй:

“23.8.14.бэлчээр ашигласны төлбөр.”

“2 дугаар зүйл.Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.1.7, 58.2.8, 58.4.5 дахь заалтын “бэлчээрийн менемент хийх” гэсний дараа “бэлчээрийн даацыг тохируулах, бэлчээрийг доройтлоос сэргийлэх, сайжруулах, хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэх;” гэж, 58.3.4 дэх заалтын “хөгжүүлэх” гэсний дараа “мал бүхий дүүрэгт бэлчээрийн менемент хийх, бэлчээрийн даацыг тохируулах, бэлчээрийг доройтлоос сэргийлэх, сайжруулах, хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэх;” гэж тус тус нэмсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Бэлчээрийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.”

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны ... дугаар
сарын ... –ны өдөр

Улаанбаатар хот

**БАЙГАЛИЙН НӨӨЦ АШИГЛАСНЫ ТӨЛБӨРИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ
ОРУУЛАХ ТУХАЙ**

“1 дүгээр зүйл. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.3, 19.1.4 дэх хэсгийг тус тус хүчингүй болгосугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Бэлчээрийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.”

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны ... дугаар
сарын ... –ны өдөр

Улаанбаатар хот

ОЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

“1 дүгээр зүйл. Ойн тухай хуулийн 9 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 4 дэх хэсэг нэмсүгэй:

“9.4. малчдын бүлэг нь энэ хуулийн 9.3-т заасан этгээдтэй гэрээ байгуулсны үндсэн дээр ойн сангийн газарт мал бэлчээж болно.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг Бэлчээрийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.”

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны ... дугаар
сарын ... –ны өдөр

Улаанбаатар хот

**ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР НУТГИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ
ОРУУЛАХ ТУХАЙ**

“1 дүгээр зүйл.Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 21 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “уламжлалт” гэсний өмнө “ бэлчээр ашиглалтын гэрээтэй малчдын бүлэг” гэж тус тус нэмсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Бэлчээрийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.”

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны ... дугаар
сарын ... –ны өдөр

Улаанбаатар хот

ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

“1 дүгээр зүйл. Зөрчлийн тухай хуульд доор дурьдсан агуулгатай 8.9 дүгээр зүйл нэмсүгэй.

“1/8.9 дүгээр зүйл.Бэлчээрийн тухай хууль зөрчих

1.Бэлчээр ашиглагч нь бэлчээрийг ашиглах, хамгаалах талаар хууль, гэрээ, журамд заасан үүргээ биелүүлээгүй бол хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

2.Эрх бүхий байгууллагын зөвшөөрөл, гэрээгүйгээр бэлчээр ашигласан, доройтол, цөлжилт үүсэх эрсдэл бүхий бэлчээрт хадлан бэлтгэсэн, хуульд заасан хохирол нөхөн төлөх үүргээ биелүүлээгүй бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж, хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

3.Хуульд заасныг зөрчиж нийтээр ашиглуулах бэлчээрт өвөлжөө, хаваржаа, хашаа саравч, барилга байгууламж барьсан, бэлчээрт шинээр авто зам гаргасан, бэлчээрийн хөрсийг эвдэх, бохирдуулах болон бусад байдлаар бэлчээрийн төлөв байдлыг алдагдуулсан, бэлчээрийн даацад нийцүүлэн малын тоог бууруулах даалгаврыг биелүүлээгүй бол хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Бэлчээрийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.”

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны ... дугаар
сарын ... –ны өдөр

Улаанбаатар хот

**ЗӨРЧИЛ ШАЛГАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ
ОРУУЛАХ ТУХАЙ**

“1 дүгээр зүйл. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6.10 дахь заалтын “13.7” гэсний дараа “13.8” гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Бэлчээрийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.”

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны ... дугаар
сарын ... –ны өдөр

Улаанбаатар хот

ГАЗРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

“1 дүгээр зүйл.Газрын тухай хуулийн 2 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 3 дахь хэсэг нэмсүгэй.

“2.3.Бэлчээрийг ашиглах, доройтлоос сэргийлэх, сайжруулах, хамгаалахтай холбогдсон харилцааг тусгайлсан хуулиар зохицуулна.”

2 дугаар зүйл.Газрын тухай хуулийн 20.1.2, 20.2.3 дахь заалтын “тухайн жилийн газар зохион байгуулалтын” гэсний дараа “болон Бэлчээрийн тухай хуулийн 17.1-д заасан” гэж, 53.2 дахь хэсгийн “иргэн” гэсний дараа “малчдын бүлэг” гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл.Газрын тухай хуулийн дараахь зүйл, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/ 52 дугаар зүйл:

“52 дугаар зүйл.Бэлчээр, түүнийг зохистой ашиглах, хамгаалах

52.1.Бэлчээрийг ашиглах, доройтлоос сэргийлэх, сайжруулах, хамгаалахтай холбогдсон харилцааг тусгайлсан хуулиар зохицуулна.”

2/ 3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 6 дахь заалт:

“3.1.6.”бэлчээр” гэж Бэлчээрийн тухай хуулийн 4.1.1-д заасныг;”

4 дүгээр зүйл.Газрын тухай хуулийн 53 дугаар зүйлийн 53.4 дэх хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

5 дугаар зүйл.Энэ хуулийг Бэлчээрийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.”

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны ... дугаар
сарын ... –ны өдөр

Улаанбаатар хот

ГАЗРЫН ТӨЛБӨРИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

“1 дүгээр зүйл.Газрын төлбөрийн тухай хуулийн “6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалтын “бэлчээрийн зориулалтаар эзэмшиж, ашиглаж байгаа газрын”, 6 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “бэлчээрийн газраас авах газрын”, 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалтын “бэлчээрийн газрын” гэснийг “бэлчээр ашигласны” гэж, 6 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “үхрийг 6,0, тэмээг 5,0, ямааг 0,9” гэснийг “үхрийг 4,0, тэмээг 3,0, ямааг 2,0” гэж тус тус өөрчилсүгэй.”

2 дугаар зүйл.Газрын төлбөрийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалтын “бэлчээр” гэснийг хассугай.

3 дугаар зүйл.Энэ хуулийг Бэлчээрийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.”

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны ... дугаар
сарын ... –ны өдөр

Улаанбаатар хот

МОНГОЛ УЛСЫН ЗАСАГ ЗАХИРГАА, НУТАГ ДЭВСГЭРИЙН НЭГЖ, ТҮҮНИЙ УДИРДЛАГЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

“1 дүгээр зүйл. Монгол Улсын засаг захиргаа, нутаг, дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалтын “а” дэд заалтын “сэргийлэх” гэсний дараа “бэлчээрийн даацыг тохируулах, бэлчээрийг доройтлоос сэргийлэх, сайжруулах, хамгаалах” гэж, “б” дэд заалтын “газар” гэсний өмнө “мал аж ахуй,” гэж, “үржил” гэсний өмнө “бэлчээрийн болон тариалангийн газрын” гэж, “м” дэд заалтын “нөхөрлөл” гэсний дараа “малчдын бүлэг” гэж тус тус нэмсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Бэлчээрийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.”

ГАРЫН ҮСЭГ